

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ХҮРТЭЭМЖ БА ХҮНИЙ ХӨГЖИЛ

Д.Хишинжаргал¹, Н.Баярмаа¹, Д.Алтайхүү¹
АШУҮИС. Дархан-АУС. СШУТэнхим
khishigjargal@mnums.edu.mn

Үндэслэл

Аливаа улс орны боловсролын системийн үндсэн үзүүлэлтүүдийн нэг болох суралцсан болон суралцах хугацаа нь тухайн улс орны хүний хөгжлийн түвшний үзүүлэлтийг илэрхийлж байна. Нөгөө талаас эдийн засгийн хувьд хөгжингүй орнуудын үндэсний орлогын өсөлт нь мэдлэг, боловсролын түвшингээр тодорхойлогдож байгаа нь дээд боловсролын үүрэг, ач холбогдлыг улам нэмэгдүүлж байна.

Дээд боловсролын хүртээмж өсөж, улмаар нийтийг хамарч буй үйл явц нь хүн амын боловсролын хүртээмжийг өргөн хүрээнд шийдэх, хүний хөгжлийн боломжийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэж байна.

Түлхүүр үг: Хүн капитал, суралцсан хугацаа, суралцах хугацаа, дээд боловсролын хамрагдалт.

Мэдлэгийн эдийн засаг ба хүний капитал:

Хүн төрөлхтөн эд баялаг, материаллаг зүйлсийг бий болгохын төлөө зорьж тэмүүлэн ирсэн боловч хөгжил дэвшил бол бүхлээрээ хүний төлөө гэдэгт тодорхой түүхийн хугацаанд бага анхаарч ирсэн байдаг. НҮБХХ-өөс 1990 онд анх “Хүний хөгжлийн илтгэл” нь дээрх хандлагыг өөрчилж, хөгжлийг үзэх үзэл, хөгжлийг бий болгох арга замыг өөрчилсөн.

“Хүмүүн капитал”-ын онолоор үндэстнийг хөгжүүлэх хамгийн үр дүнтэй зам бол хүн амыг хөгжүүлэх гэж үздэг. Улс орны хувьд ч хувь хүний хувьд ч боловсрол их чухал бөгөөд ДХХИ-д хүний хөгжлийг хэмжих 3 үндсэн үзүүлэлтүүдийн нэг нь боловсролын үзүүлэлт төдийгүй орчин үед нийгмийн давхраажилтын дөрөв дэх хэмжигдэхүүн боловсрол болсон нь түүний үүрэг, ач холбогдол улам өсөн нэмэгдэж байгаатай холбон үзэж болох юм (Алтайхүү.Д, 2018, х.38).

2012 онд дэлхийн банк жилийн турш 192 орныг хамруулан судалж улмаар улс орны эдийн засгийн өсөлтийн дөнгөж 16 хувь нь үйлдвэрлэлийн капитал, 20 хувь нь байгалийн капитал, үлдсэн 64 хувь нь хүний капиталтай тус тус холбоотой байна гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг (Никерова,Т.А, 2011, стр.168)

Сүүлийн хоёр зуун жил байгалийн болон үйлдвэрлэлийн капиталын эзлэх хувь багасч, харин байнга хүн капиталын хувь хэмжээ нэмэгдэж, үйлдвэрлэлийн болон хүн капиталын хоорондын харьцаа өөрчлөгдөж ирсэн (хүснэгт 1) байна.

Хүснэгт 1. Хөгжингүй орнуудын үндэсний баялагийн бүтцийн динамик (хувиар)

Үндэсний баялаг	Үндэсний баялагийн бүтэц, жилээр						
	1800	1860	1913	1950	1973	1998	2015
Байгалийн (түүхий эд) капитал	50%	45%	35%	20%	18%	16%	12%
Үйлдвэрлэлийн капитал	30%	33%	33%	32%	26%	19%	10%
Хүн капитал	20%	22%	32%	48%	56%	65%	78%

Харин хөгжингүй улс орны үндэсний баялагийн бүрэлдэхүүний дундаж үнэлгээ ойрын ирээдүйд ойролцоогоор хүн капитал 76-78 хувь, байгалийн капитал 3-5 хувь, үйлдвэрлэлийн капитал 17-21 хувьтай байна гэж үзэж байна (Кучерова,В.В, 2015, стр.58).

“Мэргэжлийг бус тухайн мэргэжлээр амьдрах амьдралыг хүн бүр сонгодог” болохоор боловсролын үйлчилгээний зах зээлийг хүн бүрийн маргаашийн амьдралаа сонгох сонголтын зах зээл гэж үзэж болох бөгөөд тэрээр улс үндэсний орлогын өсөлтийг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэж байна.

Дээд боловсрол нь хөгжлийн нэг гол хөдөлгөгч хүч болох нь: Хүний хөгжил гэдэг нь дэлхий ертөнцөд хөгжлийг тэгш, тогтвортой болгоход

идэвхтэй оролцох өргөн эрх чөлөөг хангах явдал юм. Хүмүүс бол өөрийн биеэр болон хамтдаа хүний хөгжлийн үр шимийг хүртэгчид төдийгүй хөдөлгөгч хүч нь юм. Тиймээс дэлхийн улс орнууд, тэр дундаа Ази тивийн улсууд хөгжлийнхөө зорилгыг хүнээ хөгжүүлэхэд чиглүүлж “Хүний хүчээр хөгжинө” хэмээн тодорхойлж байна (МУ-ын ХХИ, 2016, х.4).

Боловсролын байгууллагуудын өндөр мэргэжлийн төгсөгчдийг бэлтгэн нийлүүлэх нь ерөнхий боловсролоос эхлээд дээд боловсрол, төгсөлтийн дараах мэргэжлийн боловсрол олгох хүртэл хангалттай их цаг хугацаа шаарддаг. Монгол улс нь дэлхийн бусад улс орны нэгэн адил тасралтгүй боловсрол олгох нөхцөлийг хангахад тэмүүлж байна. Бие хүнийг төлөвшүүлэх,

цаашилбал тодорхой ур чадварыг олж авах буюу суурь боловсролын хугацаа олон улсын хэмжээнд дунджаар 9-10 жил байгаа бол суралцсан дундаж хугацаа нь 13 жил байна.

Судлаачийн зүгээс сургуульд суралцсан дундаж хугацаа ба сургуульд суралцах хугацааг голлох үзүүлэлт болгон хүний хөгжлийн түвшингээр нь улс орнуудыг бүлэглэн (хүснэгт 2) авч үзлээ. 2008 оноос 2019 он хүртэл хугацаанд

суралцсан дундаж хугацаа ба суралцах хугацааны хоорондын ялгааны өөрчлөлтийг авч үзвэл хүний хөгжлийн түвшин доогуур улс орнуудын хувьд 234,4-өөс 191.8, дээд улс орнуудын хувьд 141.0-ээс 132.7, харин дундаж улс орнуудын хувьд 215.1-ээс 182.5 болж буурсан бол хүний хөгжлийн түвшин дээгүүр улс орнуудын хувьд 154.5-аас 166.7 болж нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Хүний хөгжлийн түвшинг илэрхийлэх улс орнуудын ангилал

Хүний хөгжлийн түвшний зэрэглэл	Сургуульд суралцсан хугацаа, жилээр	Сургуульд суралцах хугацаа, жилээр	Сургуульд суралцсан болон суралцах хугацааны харьцуулалт (хувиар)
2008 он			
дээд	11,7	16,5	141,0
дээгүүр	8,8	13,6	154,5
дундаж	5,3	11,4	215,1
доогуур	3,2	7,5	234,4
2019 он			
дээд	12.2	16.3	132.7
дээгүүр	8.4	14.0	166.7
дундаж	6.3	11.5	182.5
доогуур	4.9	9.4	191.8

Эх сурвалж: Statistical annex, HDR-2014, 2020 өгөгдөлд үндэслэсэн судлаачийн нэгтгэл

Харин хүний хөгжлийн түвшин доогуур улс орнуудын хувьд суралцсан хугацаа 3,2-оос 4,9 жил, хүний хөгжлийн түвшин дундаж улс орнуудын хувьд 5.3-аас 6.3 жил болж нэмэгдсэн бол хүний хөгжлийн түвшин дээд, дээгүүр улс орнуудын хувьд харьцангуй тогтвортой шинжийг агуулж байна.

Хүний хөгжлийн түвшний үзүүлэлт ба суралцах суралцсан хугацааны ялгааг вариацийн шинжилгээгээр авч үзвэл (хүснэгт 3) хүний хөгжлийн түвшин нь суралцах дундаж хугацааны хэлбэлзлийг 71,3 хувиар, харин суралцах хугацааны хэлбэлзлэлийг 69,9 хувиар илэрхийлж байна. Энэхүү эмпирик хамаарлын ач холбогдол нь улс орнуудын боловсролын үзүүлэлт ба хүний хөгжлийн түвшний хоорондын шууд хамаарлыг харуулж байна.

Хүснэгт 3.: Суралцсан хугацаа ба суралцах хугацааны нөлөөллийн ялгаа

үзүүлэлтүүд	дундаж, жилээр	s ²	d ²	h ² , %	η
Сургуульд суралцсан хугацаа	7,9	8,08	6,67	71,29	0,84
Сургуульд суралцах хугацаа	12,81	9,35	5,65	69,94	0,83

Эх сурвалж: Statistical annex, HDR- 2015, 2020 өгөгдөлд үндэслэсэн судлаачийн тооцоолол

Харин Монгол улсын хувьд сургуульд суралцсан хугацаа 1990-2020 оны хооронд 7.7 жилээс нэмэгдэж 10.3 жил болсон бол суралцах дундаж хугацаа нь 10.2-оос 15.5 жил болж өссөн байна. Харин тэдгээр үзүүлэлтүүдийн ялгаа нь 1990 онд 2.5 жил байсан бол 2005 онд 4.1 жил, 2010 онд 5.1 жил болж өссөн ба 2021 оны байдлаар 5.2 жил болж 2010 оноос 2021 оны хооронд 2.08 дахин нэмэгдсэн (Хүснэгт 4) байна.

Хүснэгт 4. Монгол Улсын Хүний хөгжлийн индексийн (ХХИ) ахиц, 1990–2020

	1990	1995	2000	2005	2010	2015	2020
Сургуульд суралцсан хугацаа, жилээр	7.7	7.8	8.2	8.6	9.5	10.1	10.3
Сургуульд суралцах хугацаа, жилээр	10.2	7.7	9.4	12.7	14.6	15	15.5
ХХИ-ийн тоон утга	0.579	0.555	0.667	0.717	0.756	0.755	0.774

Эх сурвалж: Human Development Data (1990-2020) <http://hdr.undp.org/en/data>

Дээд боловсролд суралцах хугацааг 2017 оны байдлаар авч үзвэл Турк улс 5.7 жил, Финланд 4.3 жил байгаа нь хамгийн өндөр байсан бол хамгийн бага нь Бразил улс 2.4 жил, Их Британи улс 2.9 жил байна. Харин Монгол Улсын хувьд дээд боловсрол эзэмшихээр суралцаж байгаа хугацаа нь 3.1 жил байгаа ба сургуульд суралцах хугацаа 5.3 жилээр, суралцах бодит жил 2.6-аар тус тус өссөн байна.

Эдгээр өсөлтүүдэд ЕБС 10 жилийн тогтолцооноос маш богино хугацаанд 11, 12 жилийн тогтолцоонд шилжсэн үйл явц нөлөөлсөн бөгөөд Үүнд:

- 1-р ангид элсэгчдийн насны бүтцийн өөрчлөлт (2004-2005 онд ерөнхий боловсролын сургуульд элсэх насыг 8-аас 7, 2008-2009 онд 7-оос 6 болгон бууруулсан)
- Сургалтын үргэлжлэх хугацааны өөрчлөлт (Бага ангид 1-3-р ангийг хамруулдаг байсан бол 1999 оноос эхлэн 1-4-р ангийг бага ангид, 2005 оноос 1-5-р ангийг багтаасан ба суурь боловсролын хугацаа 8-аас 9 жил болсон)
- Ерөнхий боловсролын сургуулийг 2005-2007 оны хугацаанд 5+4+2 гэсэн сургалтын тогтолцоо бүхий 11 жилийн сургуулийн системд, 2008 оноос 5+4+3 сургалтын тогтолцоо бүхий 12 жилийн сургуулийн системд шилжсэн зэрэг болно.

Дээд боловсролын нийтийг хамрах үйл явц: Улс орнуудын гол зорилго нь боловсролын зах зээлийн тоон өсөлт бус түүний тогтолцоо ба чанарыг бэхжүүлэхэд чиглэгдэхээс гадна хүртээмжийг эрс нэмэгдүүлэх, тэр ч байтугай хамгийн алслагдсан, ядуу буурай улс орон, бүс нутагт ч гэсэн дээд боловсрол бараг бүх нийтэд хүртээмжтэй байхад чиглэгдэх хандлагатай байна. Өөрөөр хэлбэл “дээд боловсролыг зөвхөн элитийн хүрээнд авч үзэж байсан үзэл үеэ өнгөрөөж, дээд боловсролын «шинэ газар нутаг» үүсч байгаа талаар яригдаж эхэлсэн нь хэтрүүлэг биш” (Алтайхүү.Д, 2018, х.5) юм. Үүнд:

- Суралцагчдын тоо: Дэлхийд дунджаар нийт залуучуудын 20-25 хувь нь их дээд сургуульд суралцаж байна. ЭЗХАХБ-ын орнуудад гадаадын оюутнуудыг оролцуулахгүйгээр дунджаар авч үзвэл бакалаврын хөтөлбөрт элсэгчдийн 45 хувийг 25 хүртэлх насныхан, магистрын хөтөлбөрт элсэгчдийн 15 хувийг 30-аас доош насныхан эзэлж байна. Мөн түүнчлэн бакалаврын хөтөлбөр болон болон түүнтэй адилтгах хөтөлбөрт суралцагчдын 84 хувийг мөн л 25 хүртэлх насныхан эзэлж байга бол энэ үзүүлэлт Бельги, Япон, Солонгост 96 хувиас илүү, харин Израиль, Швед, Швейцарьт 70 орчим хувийг (Education at a Glance 2021. 188-197) эзэлж байна.
- Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо: Их сургуулиудын Олон Улсын Холбооны (IAU) мэдээллээр дээд боловсролын диплом олгодог 17000 гаруй байгууллага байдаг. Гэхдээ энэ мэдээллийн санд бүртгэлгүй олон их дээд сургууль байдаг бөгөөд зөвхөн Энэтхэгт л гэхэд 20 мянга гаруй их сургууль байдаг байна.
- Дээд боловсрол нийтийг хамрах үйл явц, хандлага нэмэгдэж байгаа нь насан туршийн боловсролын үзэл баримтлал болон юуны өмнө боловсролын шинэ эрэлтийг үүсгэж буй боловсон хүчнийг давтан сургах шаардлагаар нөхцөлдөж байна.

Өсөн нэмэгдэж буй дээд боловсролын эрэлтийг нь дээд боловсролын үйлчилгээний зах зээл дээрх нийлүүлэгчдийн голлон тодорхойлж буй хүчин зүйл бол нэг талаас хөдөлмөрийн зах зээл, өргөн утгаар нь авч үзвэл эдийн засгийн бүтэц, түүнийг нөхцөлдүүлж буй үйл явц, нөгөө талаас “худалдагчийн зах зээлээс худалдан авагчийн зах зээл рүү байнга хувьсан шилжиж байгаа үйл явц” (Алтайхүү.Д, 2018, х.15) юм.

Дүгнэлт

Аливаа үндэстнийг хөгжүүлэх хамгийн үр дүнтэй зам бол хүн амыг хөгжүүлэх бөгөөд үндэсний орлогын өсөлт нь мэдлэг, боловсролын түвшингээр тодорхойлогдож байгаа үйл явц нь дээд боловсролын үүрэг, ач холбогдлыг улам нэмэгдүүлж байна.

Тиймээс дээд боловсролын хүртээмж нийтийг хамарч буй үйл явц нь хүний хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж байна. Боловсролын үзүүлэлт болох суралцсан, суралцах хугацаанаас хүний хөгжлийн түвшин шууд хамааралтай байна.

Манай оронд ЕБС 10 жилийн тогтолцооноос маш богино хугацаанд 11, 12 жилийн тогтолцоонд шилжсэн үйл явцын үр дүнд 5.3 жилээр, суралцах бодит жил 2.6-аар тус тус өссөн нь хүний хөгжлийн индексийн өсөлтөд хүчтэй нөлөөлсөн байна.

Улс орнуудын гол зорилго нь боловсролын тогтолцоо ба чанарыг бэхжүүлэхээс гадна түүний хүртээмжийг эрс нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгаа нь дээд боловсрол нийтийг хамрах үйл явц болон суралцагчдын болон сургалтын байгууллагын динамик өсөлтөөс шууд хамаарч байна.

Ном зүй

1. Алтайхүү.Д, (2018), Дээд боловсролын олон улсжих үйл явц, цаашдын хандлага. Боловсрол судлал. 7(145), х.3-10
2. Алтайхүү.Д, (2018), Монголын дээд боловсролын өсөлтийн байдал, түүнийг судалсан зарим үр дүн. Дисс, МУБИС. УБ, х.15, 32-42
3. Кучерова, В. В. (2015). Формирование рынка образовательных услуг в условиях модернизации высшей школы, дисс, М, стр.44-54.
4. Никерова, Т. А. (2012). Механизм управления человеческим капиталом региона в интересах инновационного развития. Дисс, ВлГУ, стр.168-174.
5. Human Development Report. (1990, 2014, 2015, 2018, 2020)
6. Education at a Glance 2021. (2021), p 188-197. https://www.oecd-ilibrary.org/education/education-at-a-glance-2021_22bcdfd2-en. Хандалм 2021.10.18
7. <http://data.uis.unesco.org> (The UNESCO Institute for Statistics)
8. <http://www.nso.mn/> (Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо)